



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/154

Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх голын голдирлыг өөрчлөх ажлыг “Тулгат зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулж гүйцэтгүүлсүгэй.

2. “Тулгат зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлтийн гэрээ байгуулж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг орлогч дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч, зардалд шаардагдах 36,000,000 (гучин зургаан сая) төгрөгийг гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

87730137

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/